

ОРЧУУЛГА, НИЙТЛЭЛ, МЭДЭЭЛЭЛ

СОЦИАЛИСТ ЧИГ БАРИМЖААТ ОРНУУД

Л. Хайсандай

Түүхийн ухааны дэд эрдэмтэн

Дэлхийн хоёрдугаар дайнд Зөвлөлт Холбоот улс болон энхийг эрхэмлэгч бусад хүчин фашист булаан эзлэгчдийг бут цохисны үрээр дэлхийн социалист систем бүрэлдэн тогтож, улс түмний үндэсний эрх чөлөөний тэмцэл эрчимтэй өрнөх болсон нь дарлагдсан ард түмэн империалист колонийн боолчлолоос чөлөөлөгдөх шинэ үе шатыг нээсэн билээ. Энэ түүхт үйл явцыг олон улсын коммунист, ажилчны намуудын төлөөлөгчдийн Москвагийн (1960 оны) зөвлөлгөөний мэдэгдэлд «үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний давшилтанд колоничлон боолчлох ёс сүйрч унасан нь түүхэн ач холбогдолоороо дэлхийн социалист систем бүрэлдэн тогтсон явдлын дараа орох үзэгдэл мөн»¹ гэж дүгнэн тэмдэглэжээ.

70-аад онд империализмийн колонийн систем үндсэндээ сүйрч гүйцлээ. Дэлхийн бөмбөрцөг дээр социалист, капиталист орнуудын зэрэгцээгээр шинэ тутам тусгаар тогтносон хэдэн арван улс үүссэнээр орчин үеийн дэлхийн газрын зураг үндсээрээ өөрчлөгдлөө. Одоо дэлхий дээр 160 гаруй улс оршин тогтнож байгаагийн зуу орчим нь дайнаас хойших хугацаанд колонийн ба хагас колонийн хараат байдлыг халж, эрх чөлөөгөө байлдан олсны үр дүнд тусгаар тогтносон юм. Эдгээр орныг эдүгээ «чөлөөлөгдсөн орнууд» гэж нэрлэж байна.

Шинэ тулгар чөлөөлөгдсөн орнуудад нийгэм эдийн засгийн ямар харилцаа тогтох нь вэ гэдгийг эхний үед итгэлтэй хэлчих аргагүй байлаа. Тэр үед эдгээрт тулгарсан түүхэн салаа замын тухай, замаа сонгох зорилт шийдвэрлэгдээгүй байгаа тухай олонтоо бичиж, ярьж байв. Хорь, гучаад жил өнгөрсний дараа одоо байдал тодорч, чөлөөлөгдсөн бүх оронд хөгжлийн чиглэл тодорхойлогдож, нэгэнтээгүүр социалист чиг баримжаа, социалист хөгжлийн тухай, нөгөөтэйгүүр капиталист загвараар хөгжих тухай ерөнхийд нь ярьж болохоор болжээ.

Гэвч капитализмын замаар явах болсон орнуудын хувьд нийгмийн хөгжлийн сонголт хийх асуудал урьдын адил байсаар байна. Учир нь эрх баригч бүлгийнхэн нь хөрөнгөтний харилцааг хүчээр тулган хүлээлгэж байгаа орнууд капиталист замд баттай орсон гэж хараахан батлаж болохгүй билээ. Социализм түүхэн хөгжлийн хамгийн их нөлөөтэй хүчин, нийгмийн дэвшлийг асар их хурдасгагч болоод байгаа өнөө үед дэлхий дахины төрх байдал нь «коммунист, капиталист хоёр аж ахуй, хоёр байгуулал, хоёр аргын тэмцэлдээнээр»² тодорхойлогдож байна. Өөрөөр хэлбэл хөгжлийн гурав дахь зам нийгмийн гурав дахь байгуулал гэж байхгүй.

В. И. Ленин бүр хорин хэдэн оны зааг дээр «дэлхийн хувьсгалын хойчийн шийдвэрлэх тулалдаанд дэлхийн бөмбөрцгийн олонхи хүн

¹ «Программные документы борьбы за мир, демократия и социализм». М., 1961, с. 64.

² В. И. Ленин. Зохиолууд. 31-р боть 448 дахь тал.

амын хөдөлгөөн эхлээд үндэсний эрх чөлөөгөө олоход чиглэж байгаад капитализм, империализмын эсрэг зайлшгүй эргэнэ»³ гэж зөнч мэргэнээр угтан харсан юм. Барагцаалбал тэгэхэд Ленин заахдаа, тийм боломж нь Оросын социалист хувьсгалын ялалтын ачаар бодит болон биелж болно гэж байжээ. Коминтерний II их хурал дээр үг хэлэхдээ: «...одоо чөлөөлөгдөж байгаа ба түүний дотор дайны дараа одоо давшилтын замаар хөдөлж байгаа нь мэдэгдэж байгаа хоцрогдсон тийм ард түмэнд ардын аж ахуйн хөгжлийн капиталист шат залшгүй хэрэгтэй юу гэдэг баталгааг зөв гэж үзэж болох уу?...Бид энэ асуултыг тийм биш гэж хариулав... Тэргүүний орны пролетари нарын тусламжтайгаар хоцрогдсон орнууд зөвлөлт байгуулал ба хөгжлийн тодорхой шатыг дамжиж, капиталист хөгжлийн шатыг алгасан коммунизмд хүрч чадна»⁴ гэсэн юм.

Боломж бодитой болж биеллээ. Тухайлбал, хөгжлийн капиталист биш зам нь ЗХУ-ын дорно дахины бүгд найрамдах улсуудын ард түмэн, БНМАУ болон социалист бусад зарим орны хөгжлийн түүхээр шалгагдаж, тэдний амьд практикт биеллээ олов. Капиталист шатыг алгасан социализмд шилжсэн тэдгээрийн энэ практик туршлага хийгээд нийт социалист системийн өсөлт бэхжилт нь чөлөөлөгдсөн орнуудын ард түмний тэмцлийг хөнгөвчилж, энэ тэмцэл феодалын ба капиталист мөлжимтгий харилцааны эсрэг чиглэсэн нийгмийн эрх чөлөөний тэмцэл болон лавшрахад үлэмж тус дөхөм болж байна.

Өнөө үед үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний бүс дэх хувьсгалт үйл явцын үндсэн чиглэл, агуулга нь социализм өөд зорин тэмүүлсэн нийгэм-эдийн засгийн өөрчлөлтүүдээр улам бүр тодорхойлогдож байна. Үүний нэг тод жишээ бол одоо Ази, Африк, Латин Америкт нийт арван сая гаруй ам дөрвөлжин километр газар нутаг, 200 шахам сая хүн ам бүхий 20 гаруй орон социалист чиг баримжааг сонгон авч хөгжиж байгаа явдал мөн. Ийм улс орон жилээс жилд өсөн нэмэгдэж байгаагийн зэрэгцээгээр тэнд хувьсгалт өөрчлөн байгуулалт гүнзгийрч байна.

Тийнхүү хүн төрөлхтөний нэн шинэ үеийн түүхэнд хөгжлийн капиталист биш замын түүхэн гурван хэлбэр гарсаныг бид олж харж байна. Үүнд: Нэгдэх хэлбэр нь ялсан пролетарийн ууган орон, олон үндэстний нэгдмэл улс—Зөвлөлт Холбоот Улсын хүрээнд (зөвлөлүүдийн орны дорно дахины бүгд найрамдах улсуудын ард түмэн) капитализмыг алгасан социализмд шилжсэн хэлбэр мөн. Хоёр дахь хэлбэр нь биеэ даасан тусгаар орон БНМАУ-ын нөхцөлд болон мөн социалист бусад зарим орны практикт биелэлээ олсон юм.

Хаант Оросын хоцрогдмол хязгаар байсан үндэстэн ястан ард түмэн болон БНМАУ-ын түүхэн туршлага нь хөгжлийн капиталист биш замын тухай марксист-ленинист сургаалын үнэн бодитой амьдрах чадвартайг нотолсон төдийгүй чөлөөлөгдсөн орнуудын улс түмний хувь заяанд хувьсгалжуулагч нөлөө үзүүлж байна.

Социалист чиг баримжаат хөгжил бол хөгжлийн капиталист биш замын гурав дахь хэлбэр, түүний орчин үеийн практик биелэл мөн. Одоо үед «социалист чиг баримжаа» гэдэг ойлголт коммунист, ажилчны намуудын болон хувьсгалт дэвшилт өөрчлөлтийн замд орсон чөлөөлөгдсөн орнуудын нам, төрийн албан ёсны баримт бичигт баттай үндэслэлтэй байр эзэллээ.

³ Мөн тэнд. 32-р боть. 494 дэх тал.

⁴ В. И. Ленин. Зохиолууд, 31-р боть. 230 дахь тал

Жишээ нь: 1969 онд Москвад болсон коммунист ажилчны намуудын олон улсын зөвлөлгөөний Үндсэн баримт бичигт: «Манай үеийн хувьсгалт нөхцөл байдлын нөлөөгөөр чөлөөлөгдсөн орнуудын нийгмийн дэвшилт хөгжлийн өвөрмөц хэлбэрүүд үүсэж, хувьсгалт ардчилсан хүчний үүрэг их болов. Шинэ тулгар зарим улс хөгжлийн капиталист биш зам-колониин үеэс улиран уламжилсан хоцрогдлыг арилгаж, социалист хөгжилд шилжих нөхцөлийг бүрэлдүүлэх боломжийг хангах замд оров. Эдгээр орны социалист чиг баримжаа нь ихээхэн бэрхшээл, сорилт шалгалтыг даван туулж, өөртөө зам гаргаж байна...»⁵ гэж тэмдэглэжээ.

Социалист чиг баримжаат орон дэвшилт замаар гэхдээ нарийн төвөгтэй нөхцөлд харилцан адилгүй хөгжиж байна. Гэвч үндсэн чиглэл нь адил төстэй юм. Энэ нь империалист монополи, орон нутгийн том хөрөнгөтөн, феодалуудын байр суурийг аажмаар устгах, гадаадын капиталын үйл ажиллагааг хязгаарлах явдал юм. Энэ нь эдийн засгийн зонхилох газруудыг ардын төрийн мэдэлд авах, үйлдвэрлэх хүчнийг төлөвлөгөөтэйгээр хөгжүүлэх замд шилжин орох, тосгонд хоршооллын хөдөлгөөнийг хөхүүлэн дэмжих явдал юм. Энэ нь нийгмийн амьдралд хөдөлмөрчин олон түмний гүйцэтгэх үүргийг дээшлүүлэх, ард түмэнд үнэнч үндэсний боловсон хүчнээр төрийн байгууллагуудыг аажмаар бэхжүүлэх явдал юм. Энэ бол эдгээр орны гадаад бодлогын империализмыг эсэргүүцэгч шинж чанар юм. Эдгээр оронд хөдөлмөрчин өргөн олны эрх ашгийг илэрхийлсэн хувьсгалт намууд бэхжиж байна.⁶ Үүнд хөгжлийн капиталист биш замыг туулсан орнуудын хувьсгалт ардчилсан өөрчлөлтийн мөн чанар, үндсэн агуулга оршиж байгаа нь илхэн байна.

Социалист чиг баримжаат орнууд нийгмийнхээ программын хүрээнд чухам юу хийгээ вэ? гэдгийг тоймлон авч үзье. Африк тивийн хүн амын 25, газар нутгийн 30 хувийг эзэлдэг социалист чиг баримжаат орнуудаас жишээ нь Этиопит томоохон үйлдвэрүүдийг төдийгүй дунд зэргийн үйлдвэр, эдийн засгийн байгууламжуудыг нийтээр нь улсын болгосон бөгөөд хөдөө нутагт газар тариалангийн шинэтгэл хийсэн нь феодал-помещикийн газрыг хурааж, олон зуун мянган ядуу, дунд тариачны өрхөд хуваарилан олгосноор феодалын газар эзэмшлийг бараг бүрмөсөн устгасан байна. Алжирт эдийн засгийн улсын салбар аж үйлдвэрийн бүтээгдэхүүний 90 хувийг үйлдвэрлэж байна. Урьд нефть олборлох аж үйлдвэр бараг тэр аяараа гадаадын капиталын гарт байсан бол одоо тус орны үндэсний СОНАТРАК каипани нефть, хий олборлож боловсруулах ажлыг бүрэн хянаж байна. Алжирт хөдөө аж ахуйн шинэтгэлийг үндсэндээ дуусчээ. Улсын салбар бэхжиж, түүнийг төлөвлөгөөний үндсэн дээр хөгжүүлж байгаагийн үр дүнд Конго улсын эдийн засгийн хөгжлийн хурдац тусгаар тогтнолын жилүүдэд хоёр дахин өссөн байна. Африкийн орнуудад хүнсний асуудал хамгийн хурцаар тавигдаж байгаа одоо үед Бенин улс өөрийн хүнсний гол бүтээгдэхүүнээр хэрэгцээгээ бүрэн хангадаг болжээ. Гадаад худалдаа, тээвэр, эрчим хүч, импорт, нефть, нефтийн бүтээгдэхүүний хуваарилалт, банк, даатгалын компаниуд улсын мэдэлд шилжжээ. Бениний байгалийн баялгийг ард түмний өмч болов. Тус улсын гол үйлдвэрүүдийн гуравны хоёр гаруй хувь нь одоо улсын болон холимог салбарт хамрагдаж байна. Мадагаскарт улс ардын аж ахуйг хөгжүүлэх таван жилийн төлөвлөгөө төдийгүй 2000 он хүртлэх хэтийн төлөвийг бо-

⁵ «Коммунист ажилчны намуудын олон улсын зөвлөлгөөний баримт бичгүүд» УБ., 1969, 33 дахь тал.

⁶ «ЗХУКН-ын XXVI их хурал» УБ., 1981, 19 дэх тал.

ловсруулжээ. Афиркийн социалист чиг баримжаат орнуудад нийгмийн засаг, соёлын гүнзгий өөрчлөлтийг хэрэгжүүлж байгаагийн дүнд ард түмний амьдрал, соёлын хэмжээ дээшлэх болов. Түүнчлэн ард түмний ардчилсан эрх чөлөөг үндсэн хуулиар баталж өгсөн нь бас нэг томоохон амжилт мөн.

Азийн социалист чиг баримжаат орнуудаас тухайлбал Афганистанд үйлдвэрийн газрын 40 орчим хувийг улсын болгосны дотор цахилгаан эрчим хүч, чулуун нүүрс, байгалийн хий, боловсруулах үйлдвэр орж байна. Тус улсын 27 мужид газрын шинэтгэл хэрэгжүүлсэн бөгөөд одоогийн байдлаар олон зуун мянган тариачин өрхөд нийтдээ гурван сая гаруй жериб (нэг жериб нь 0,2 га-тай тэнцэнэ) эдэлбэр газар олгожээ. Афганистанд тариачдыг хоршооллох хөдөлгөөн өргөн далайцтай өрнөж байгаа бөгөөд 1982 оны байдлаар хөдөө аж ахуйн 1200 гаруй хоршоолол байгуулагдаж, тэдгээрийн гишүүд 200 мянгаас давжээ.

Бичиг үсэг сурах зорилтыг хангах, ардын боловсрол, эрүүлийг хамгаалахыг хөгжүүлэх талаар их ажил хийж байна. 1983 оны байдлаар бичиг үсэг сургах 31625 курст 632500 гаруй хүн суралцаж байна.⁷ Ийм курсуудад суралцагч, төгсөгч мөн багшлагч олширч сургалтын хэлбэр, агуулга үлэмж дээшилж байна.

Кампучийн ард түмэн эрх чөлөө олсны дараа улс орныхоо бүхий л амьдралыг цоо шинэ үндсэн дээр сэргээн босгох хувьсгалт зорилтыг шийдвэрлэхэд юуны өмнө эдийн засгийн гол салбар болсон хөдөө аж ахуйг төлөвлөгөөтэйгээр өөрчлөн байгуулах (газар тариалан, мал аж ахуйг хослон хөгжүүлэх, атар газар эзэмших, механикжуулах, услалтын системийг сайжруулах, тутаргын талбайг нэмэгдүүлэх, техникийн ургамлын үйлдвэрлэлийг өргөтгөх зэрэг) талаар тодорхой амжилтанд хүрч байна. Энэ зорилгын үүднээс ойрын таван жилд (1981--1985) тариалангийн талбайг 2,3—2,5 сая га-д үхэр сүргийн тоо толгойг 1,4—1,5 сая хүргэхээр төлөвлөсөн нь амжилтай биелж, сүүлийн 2 жилд цагаан будааны үйлдвэрлэл 3 дахин өссөнөөр улс орныг нөмөрч байсан өлсгөлөнгийн аюулыг арилгасанаар барахгүй хоол хүнсний гол хэрэгцээг нөөцөөр хангах болов.⁸ Мөн зарим үйлдвэрийн үндсэн түүхий эд болох техникийн ургамал тариалах талбай, түүнээс хурааж авах ургацын хэмжээ үлэмж өсч, тухайлбал 5000 га-д каучук, 1500 га-д хөвөн, чихрийн нишингэ тариалж, тариалангийн талбайгаас хурааж авсан ургацын хэмжээг 1,7 сая тонн-д хүргэжээ.⁹

Хөдөө аж ахуйг хамтын хөдөлмөрийн замд шилжүүлэх үйл явцын эхлэл болох «үйлдвэрлэлийн харилцан туслах бригад»-д бүх тариачин өрхийн 90 гаруй хувь нь хамрагдаж байна. Одоо Кампучид «үйлдвэрийн харилцан туслах бригад» зуу шахам мянга ажиллаж байна.¹⁰ Загасчид, гар урчуудын дотор бас ийм хоршооллын хэлбэрүүд бий болж байна. Одоо тус олон арван үйлдвэрийн газар (тухайлбал нэхмэл, резинэн эдлэл, ундаа, тамхины үйлдвэр цахилгаан станц, техник засвар, ус цэвэрлэх төхөөрөмж, нийтийн ахуйн үйлчилгээний төв зэрэг) сэргээн босгогдож улсын чанартай хэвийн байдлаар ажиллаж байна.

Өнгөрсөн богино хугацаанд кампучийн ард түмэн пол потынхноос үндэсний соёл боловсрол, эрүүлийг хамгаалах салбарт учруулсан хохирлыг арилгах талаар их ажил хийж, одоо тус улсад 6 мянга гаруй

⁷ «ДДСА» 1983. № 1(8) 90 дэх тал.

⁸ Мөн тэнд. 1982, № 2 (7) 47 дахь тал.

⁹ «Азия и Африка сегодня» 1982, № 1, 12 дахь тал.

¹⁰ Мөн тэнд. 13 дахь тал.

бага, бүрэн бус дунд сургуульд сая гаруй охид хөвгүүд суралцаж байна. Багш нар 20 мянгад хүрэв.¹¹

Соёл гэгээрэл, эрүүлийг хамгаалах, худалдаа, санхүү, тээвэр холбоо зэрэг улс ардын аж ахуйн төрөл бүрийн салбарт үндэсний мэргэжилтэй боловсон хүчнийг түр сургуулийн хэлбэрээр бэлтгэн гаргаж байна. Одоо тийм сургуулиудад 10 шахам мянган кампучи хүмүүс суралцаж байна. Пномпень хотоо багшийн дээд сургууль болон анагаах, эм найруулагчийн факультетууд ажиллаж байна. Бүх муж больництой болж, хүн ам эмнэлгийн үйлчилгээгээр хангагдах үндэс суурь тавигдав.

Сири, Өмнөд, Йемен, Бирм зэрэг оронд эдийн засгийн томоохон салбарууд, түүний дотор банк, тээвэр, гадаад худалдааг улсын хяналтанд шилжүүлж, гадаадын болон хувийн капиталын үйл ажиллагааг хязгаарлах эдийн засгийн улсын салбарууд бий болгож хөгжүүлэх талаар дорвитой алхам хийж байна. Сирид улсын салбар үйлдвэр байгууллагын дөрөвний гурав шахам хувьд улсын хяналт тогтоожээ. Бирмд улсын салбар үндэсний эдийн засгийн 50 хувийг эзэлж байна.¹² Үүний хамт эдгээр оронд газар тариаланг шинэчлэн өөрчлөх, хөдөө аж ахуйг хоршоолоход их анхаарал тавьж, багагүй амжилт олж байна. Ингэхгүйгээр хүн амын хүнсний асуудлыг шийдвэрлэх боломжгүй юм. Латин Америкийн Никарагуа, Гайан зэрэг оронд социалист чиглэлтэй адил төстэй өөрчлөлт хийж эхэлж байна. Мөн Гренадад социалист чиг баримжааны чиг шугам нэлээд ахицтай хэрэгжиж байсан юм.

Социалист чиг баримжаат орнуудад хөдөлмөрчдийн эрх ашигт нийцсэн нийгмийн бусад чухал хувьсгалт өөрчлөлтүүд хийгдэж байна. Үүнд: ажлын цагийг найм болгон цөөлж цалин хөлсний баталгаатай доод хэмжээ тогтоон, нийгмийн даатгалын систем, тэтгэвэр бий болгож, үнэ төлбөргүй сургалт, эмнэлгийн үйлчилгээтэй болж байна.

Нэг тэмдэглүүштэй зүйл бол сүүлийн жилүүдэд социалист чиг баримжаат орнуудад марксизм-ленинизмийн үзэл санаа, ажилчин ангийн намын зарчмыг удирдлага болгоно гэж тунхагласан хөдөлмөрчдийн манлай хувьсгалт ардчилсан нам байгуулагдаж, өсч төлөвшиж байгаа явдал мөн. Эдгээр орны улс төрийн амьдралд хувьсгалт ардчилсан нам шийдвэрлэх үүрэг гүйцэтгэж удирдан чиглүүлэгч гол хүч нь болж байна.

Нийгэм-эдийн засгийн ийм шинэчлэлт өөрчлөлтийг нэлээд эртнээс хэрэгжүүлж эхэлсэн орнуудад Алжир, Бирм, Гвиней, Өмнөд Йемен, Конго, Сири зэрэг орон орж байна. Афганистан, Ангол, Бенин, Кампучи, Мадагаскар, Мозамбик, Этиоп зэрэг орон хожим нь энэ замаар замнах болсон юм. Үүнээс үзэхэд ази, африкийн зарим орон бүр хорь шахам жилийн өмнө социалист чиг баримжааны замд орж, шинэ амьдрал цогцлон байгуулах талаар тодорхой туршлага хуримтлуулаад байна. Тэгэхдээ энэ туршлагад дан ганц ололт амжилт төдийгүй бас саад бэрхшээл, шийдвэрлэгдээгүй асуудал, алдаа эндэгдэл бий нь мэдээж. Өөрөөр хэлбэл социалист чиг баримжаат орнууд социализмд хүрэх зам өөд ямар ч саад бэрхшээлгүй, шулуун шуудхан яваагүйг амьдрал туршлага харуулж байна. Эдгээр оронд пролетари биш завсрын давхраа зонхилж, тэдэнд жижиг хөрөнгөтний төсөөлөл байнга нөлөөлж, ажилчин анги улс төр, зохион байгуулалт, эдийн засгийн

¹¹ Мөн тэнд 13 дахь тал.

¹² «Государственный сектор и социально-экономический прогресс в развивающихся странах» Киев, 1980. 24 дэх тал.

талаар гүйцэд төлөвшөөгүй юм уу хараахан бүрэлдэж тогтоогүй, феодал, овог аймаг, эцгийн ёсны уламжлал хүчтэй байгаа, соёлын талаар хоцрогдмол, капиталист зах зээлийн нөлөө их байгаа зэрэг нь социалист чиг баримжаат зарим орны гадаад дотоод бодлогод хэлбэлзэл, ухралт гардгийн гол шалтгаан юм.

Социалист чиг баримжаат хөгжлийн үйл явцад тухай орны доторхи ангиудын хүчний харьцаа, байр суурь зэрэг олон хүчин зүйл тал бүрээс нөлөөлж байна. Иймээс хялбарчлах юм уу загварчлах, яарах юм уу гуйвж дайвах явдал социалист чиг баримжаат хөгжилд аюул учруулж байна. Үүнийг Гана, Мали, Египет, Сомали зэрэг орны жишээнээс харж болно.

Нөгөөтэйгүүр, империалист харгис хүч социалист чиг баримжаат орнуудыг сонгож авсан замаас нь гаргаж, шинэ колоничлолын урьхинд оруулж авахын тулд эдийн засгийн шахалт хавчилт үзүүлэхээс эхлэн цэргийн эргэлт зохион байгуулах, зэвсэгт түрэмгийлэл үйлдэх хүртэл зүйл бүрийн арга хэрэглэж байна. Ингэхдээ тэд тухайн орны харгис хүчийг өөгшүүлэн тэтгэж дэмжих, дэвшилт дэглэмийн олон улсын байр суурийг сулруулах явдалд анхаарлаа төвлөрүүлж байна. АНУ-ын империализм, тэдний гар хөл бологсод, Ангол, Афганистан, Кампучи, Никарагуа, Өмнөд Йемен, Этиопийн эсрэг эдийн засаг, цэрэг-улс төр, үзэл суртлын ширүүн дайралт хийсээр байгаа бөгөөд Гренада улсыг цэрэг зэвсгийн хүчээр шууд эзлэн авч, тэнд амжилттай хэрэгжиж байсан социалист чиг баримжаат өөрчлөн байгуулалтыг бусниулан зогсоолоо. Энэ мэт бэрхшээл дундуур социалист чиг баримжаат олонхи орнууд улам ахицтай амжилтанд хүрч империалист болон харгис бусад хүчний дайсагнасан бодлого, ажил явууллага бүрийг даван туулж, сонгож авсан замаараа тууштай замнаж байна.

Ийнхүү социалист чиг баримжааны замаар амжилттай ахин давшихад нь ЗХУ болон социалист хамтын нөхөрлөлийн бусад оронтой тогтоосон, улам бүр өргөжин зузаарч байгаа жинхэнэ эрх тэгш харилцаа, үр ашигтай хамтын ажиллагаа тэргүүн зэргийн ач тус үзүүлж байна. Бодит социализмын тусламжтайгаар олон зуун аж үйдвэр, хөдөө аж ахуй, соёл, гэгээрлийн газар байгуулан, байгалийн баялгаа эзэмшиж байна. Чухамдаа бодит социализм оршин байгаа нь социалист чиг баримжаат орнуудад империалист түрэмгийллийн бодлогыг сөрөн зогсох, шинэ нийгмийн байгуулалтын түүхэн туршлагыг бүтээлчээр авч ашиглах өргөн боломж байна. Тийм учраас бодит социализмын орнууд үүний дотор БНМАУ-ын хөгжлийн түүхэн замнал, туршлага нь социализмд хүрэх замаар хөгжиж байгаа ард түмэнд зоригжуулагч үлгэр жишээ болж байгаа юм. Энэ тухай Афганистаны Бабрак Кармаль, Гвинейн Секу Туре, Кампучийн Хенг Самрин, Мозамбикийн Самора Машел, Никарагуагийн Даниэл Ортега нарын зэрэг олон зүтгэлтэн онцлон тэмдэглэсэн юм.

БНМАУ үүсэн тогтсон анхныхаа өдрөөс эхлэн улс түмний үндэсний эрх чөлөөний хөдөлгөөнийг гуйвалтгүй дэмжиж ирсэн бөгөөд эдүгээ социалист чиг баримжаат бүх оронтой дипломат, соёлын болон бусад харилцаа тогтоон хөгжүүлж байна. Энэ харилцаа, хамтын ажиллагаа улам ойр дотно, тал бүрийг хамран шинэ агуулга хэлбэрээр баяжин хөгжих сайхан төлөвтэй юм. МАХН-ын XVIII их хурлаас «Бид чөлөөлөгдсөн орнууд юуны өмнө социалист чиг баримжаат улсуудтай найрамдалт харилцаагаа хөгжүүлэх талаар цаашид ч чармайлт тавьж, Ази Африк, Латин Америкийн улс түмний эрх чөлөөний болон хувьсгалт хөдөлгөөнийг дэмжих болно» гэж заасан билээ. Манай

намын гадаад улс төрийн үйл ажиллагааны энэ чиг шугам эдүгээ амжиттай хэрэгжсээр байна.

Социалист чиг баримжааны зам бат орших чадалтайгаа харуулж, капиталист биш хөгжлийн болит зам болсон нь чөлөөлөгдсөн орнуудын социалист чиг баримжаат хөгжлийн туршлагын гол үр дүн мөн.

х х х

**Ази Африк, Латин Америкт социалист чиг баримжаагаар
замнаж байгаа орнууд:**

№	Улсын нэр	Газар нутаг (мянган кв км)	Хүн ам (саяар)
1.	Алжир	2,380	19,2
2.	Ангол	1,247	7,4
3.	Афганистан	0,647	19,8
4.	Бенан	0,113	3,4
5.	Бирм	0,687	31,2
6.	Гайан	0,215	1,2
7.	Гвиней	0,246	5,7
8.	Гвиней-Бисау	0,036	0,8
9.	Ирак	0,438	12,4
10.	Кампучи	0,181	8,6
11.	Конго	0,342	1,8
12.	Ливи	0,760	2,9
13.	Мадагаскар	0,585	9,2
14.	Мозамбик	0,783	10,4
15.	Өмнөд Йемен (БНАЙАУ)	0,288	2,3
16.	Никарагуа	0,130	2,9
17.	Ногоон хошууны арлын БН Улс	0,004	0,3
18.	Сири	0,185	9,2
19.	Танзани	0,945	16,4
20.	БН Сан Томе ба Принсипи Улс	0,01	0,085
21.	Сейшелийн арлуудын БН Улс	0,4	0,070
22.	Этиоп	1,222	29,4

Тайлбар: 1. Хүн амын тоог 1980-1982 оны үеэр авсан болно.

2. Гренада улсыг АНУ цэрэглэн эзэлж, социалист чиг баримжааны замд нь аюул учруулсан учир энд оруулаагүй болно.